

**Монгол-хятад уран зохиолын харилцаа холбооны
судлалд эрдэмтэн Д.Цогтын оруулсан хувь нэмэр**

Өлзийдэлгэрийн Саранцэцэг*

Монгол улс, МУИС, ШУС, ХУС-ийн багш,
доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг. Бэнсний үлгэр, хуурын үлгэр, Лувсан хуурч, Б.Цогт

Академич Ц.Дамдинсүрэн нэгэнтээ монгол уран зохиолын дурсгалд холбогдох хятад уран зохиолын дурсгалыг, бүхий л хувилбаруудын хамтаар цуглуулж судлах зайлшгүй шаардлагатай тухай өгүүлсэн байдаг. Тэрээр ...Монгол-хятад эртний уран зохиолын харьцаа холбоо нь зөвхөн монгол, хятад хоёр үндэстний уран зохиол болон соёлын харилцаанд л холбогдох асуудал төдий бус, харин монгол, Төвөд, энэтхэг уран зохиолын харьцаа холбоотой хамтаар бүхий л дорно дахины уран зохиол болон соёлын бүрэн бүтэн уламжлалд холбогдох асуудал болно (Дулаан. 2008. 238). Иймээс монгол-хятад эртний уран зохиолын харилцаа холбооны судлал бол дорно дахины утга соёлын бүхэл бүтэн дэвсгэр дээр монгол уран зохиолыг дэлгэр хараагаар судлахын чухал нэгэн хэсэг болох ажээ.

Орчин цагийн монгол судлалд энэхүү ажлын эхлэлийг академич Б.Ренчин 1959 онд хуралдсан Монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд “Монгол ардын аман зохиол дахь бэнсэн үлгэрийн зүйл” гэдэг илтгэл тавьж хэлэлцүүлсэн байдаг ба үүний дараа нэрт хуурч Өлзийн Лувсангийн “Баруун тивийг эзлэн төрсөн Бодь мэргэн хаан” үлгэрийг 1960 онд латин галигаар хэвлүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан шинэ үеийн монгол судлал дахь монгол-хятад уран зохиолын харилцаа холбооны судалгааны эхлэл болсон.

Академич Д.Цэрэнсодном энэ сэдвийг үргэлжлүүлэн “Бэнсэн үлгэрийн онцлог байдал” (2017) эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлжээ. Тэрээр “Ийнхүү олон мянган жилийн хөгжилд аман зохиол бичгийн уран зохиолдоо нөлөөлж ирсний дээр бичгийн зохиол ч аман зохиолынхоо хөгжилд нөлөөлж улмаар бие даасан төрөл, айг үүсгэсэн нь судлагчдын анхаарлыг татсаар иржээ.

* © Ө.Саранцэцэг 2024

Email: sarantsetseg.u@num.edu.mn

Ийм зохиолын тоонд эртний Хятадын Шань, Хан, Тан, Сүн зэрэг улсын түүх шастирын өгүүлэмжийг ашиглан монгол үлгэрч, хуурчдын зохиосон “Бэнсэн үлгэр” зүй ёсоор орно. ...Манж Чин улсын үед тухайлбал Энх-Амгалан хааны (1662-1722) сүүл үеэс Бадаргуулт төрийг (1875-1908) хүртэлх 200-аад жилд Хятадын алдарт түүхэн роман “Улаан асрын зүүд”, “Гурван улсын үлгэр”, “Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”, “Шуй хуйгийн үлгэр” хийгээд аж байдлын адал явдалт бас бус хүүрнэл зохиолыг өргөнөөр орчуулж байсан нь бидний өгүүлэн буй бэнсэн үлгэр үүсэж хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлжээ (Цэрэнсодном. 2017.11) хэмээн академич Ренчиний анх удаа тавьсан саналыг баримтаар баталгаажуулан гаргасан юм.

Дээрх хоёр судалгаа болон МУ-ын Боловсролын Их сургуулийн профессор С.Хөвсгөлийн орос хэлээр дамжуулан мэдээлсэн сурах бичигт (Хөвсгөл. 2010. 63) мөнхүү дундад зууны үе дэх хятад-монгол уран зохиолын харилцан нөлөөллийн талаар шинэ шинэ баримтуудыг дурдсан байдаг. Харамсалтай нь өнөө хэр Монгол улсын эрдэмтдээс энэ чиглэлээр дорвитой судалгааны бүтээл хараахан гараагүй бөгөөд харин БНХАУ-ын эрдэмтэд Рэнцэндорж, Дулаан, Цогт, Ван Мандуга, Хувьсгалт зэргийн олон эрдэмтэд дундад зууны үеэс уламжилж ирсэн сурвалж бичгийн хүрээнд буй монгол-хятадын уран зохиолын харилцаа холбооны асуудлаар судалгаа хийсээр байна.

Хоёр орны уран зохиолын харилцаа холбоо харилцан нөлөөллийн асуудалд хамгийн чухал том суурь эзэлсэн төрөл зүйл нь бэнсэний үлгэр, хуурын үлгэр бөгөөд энэ талаар дорвитой судалгаа хийж буй эрдэмтэн бол БНХАУ-ын Төвийн Үндэстний Их Сургуулийн доктор, профессор Б.Цогт юм. Энэ чиглэлд түүний “Хуурын үлгэрийн судлал” (2011), “Лувсан хуурчийн “Бодь мэргэн хаан”-ы судлал” (2023) зэрэг ганц сэдэвт томоохон судалгааны бүтээлүүд гол байр суурь эзэлдэг.

Б.Цогт нь 1988 онд Их сургууль төгссөн цагаас эхлэн 13 жилийн турш Бээжин, Хөх хот, Тунляо хот, Зарууд хошуу, Хорчин зүүн гарын хойд хошуу, Улаан хот, Хорчин баруун гарын дунд хошуу, Хорчин баруун гарын өмнөд хошуу, Хайлаар хот, Шинэ барга зүүн хошуу, Улаанхад хот, Ляонин мужийн Фүшин ба Фүшиний монгол үндэстний өөртөө засах Сян зэргээр тасралтгүй хээрийн шинжилгээний байцаалт хийж хуурын үлгэрийн талаар ховор нандин материал, үлгэрийг цуглуулан 2001 онд энэ сэдвээр дэд эрдэмтний зэрэг хамгаалсан юм. Энэхүү судалгааны ажлын нэгдүгээр хэсэгт хуурын үлгэр нь зүүн орны монголчуудын аж ахуй эрхлэлтийн өөрчлөлт хөгжилтөд хятадын нөлөө тусгал буй болсноос үүдэн соёл урлагийн хөгжилтөд хэрхэн нөлөөлж, өөрчлөгдөн хувьссан, энэ нь монгол аман зохиолын уламжлалтай хэрхэн уялдаа холбоотой хөгжиж ирсний нэг том гэрч болох талаас баримт нотолгоотой үзүүлж чадсан. Хоёрдугаар хэсэгтээ хуурчдын ур чадвар, хувь хүмүүсийн авьяас билгээр хэрхэн өөрчлөгдөн хөгжсөнийг үзүүлжээ. Гуравдугаар хэсэгтээ хуурын үлгэр болон монгол ардын үлгэрийн харилцаа холбооны талаар адил ба өөр тал, нийтлэг ба онцлог талуудыг

харгалдуулан гаргасан. Дөрөвдүгээр бүлэгтээ хуурын үлгэрийг хуурдан хэлэх хуурчдын хэв намба, онцлогийг онцгойлон судлан тус бүрээр ялган салгаж тодорхойлохыг оролдсон байдаг. Тавдугаар бүлэгт хуурын үлгэр дэх зан үйлийн зүйлийг судлан тодруулахыг хичээсэн байна. Уг бүтээлийн талаар эрдэмтэн С.Байгалсайхан “Судлаач Б.Цогтын “Хуурын үлгэрийн судлал” хэмээх энэхүү бүтээл нь монгол-хятадын уран зохиолын харилцаа холбоо судлалын томоохон цагаан зайг арилгахад чухал үүрэгтэй. Энэхүү ганц сэдэвт зохиол нь хятад, монголын утга зохиолын харилцаанд ихээхэн үүрэгтэй бидний бэнсний үлгэр хэмээн нэрлэж заншсан аман зохиолын төрлийг өвөр монгол нутагт хятадын бичгийн зохиол, монгол аман зохиолын уламжлалтай хослон дэлгэрсэн түүх, урлах эрдэм, зан үйлийн дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааны дүгнэлтүүдийг өгч байгаагаараа ач холбогдолтой юм” (Байгалсайхан. 2023. 7) гэж үнэлсэн байна.

Нэрт аман зохиол судлаач Мандах “Цогтын энэ “Хуурын үлгэрийн судалгаа” бүтээлд ...хуурын үлгэр ба түүний үүсэл хөгжил, хуурын үлгэрийн онцлог ба нөлөө үйлдэл, хуурын үлгэр болон бэнсний үлгэр, хуурын үлгэр болон мангасын үлгэрийн харьцаа холбоо, хуурчид ба тэдний хэв намба, урсгал бүлэг, хуурын үлгэрт холбогдох зан үйл зэрэг асуудлын талаар нэлээд дэлгэрэнгүй бөгөөд системтэй өгүүлэн тодорхойлжээ” (Мандах. 2023. 10) хэмээн дүгнэжээ.

Цогтын энэхүү хуурын үлгэрийн судлалын ажил нь нэг талаас залуу судлаачийн олон жилийн турш өвөр монголын олон аймаг хошуудаар аялан тойрч, номын сан материалын сан хөмрөг, сонин сэтгүүлийн газар, соёлын ордон, хөдөөгийн монгол гэр, шавар байшингаар бэдэрлэн гүйж, эрэн сурвалжилж, эрдэмтэн мэргэдээс асуун шалгааж, үлгэрчдээс шингээлт бичлэг хийн, тэмдэглэл хөтлөн хийсэн асар их ажил болон харагдаж байгаа боловч нөгөө талаас монгол-хятад хоёр улсын уран зохиолын харилцаа холбооны гол “түүр” болон түүхэнд үлдсэн бэнсний үлгэр, хуурын үлгэрийн анхны томоохон системтэй судалгаа болон монгол уран зохиол судлалын түүхнээ тэмдэглэгдэж байна.

Нөр их судалгааны ажил болсныг илтгэх зөвхөн тоон баримт гэхэд тус ганц сэдэвт зохиолд гуч гаруй муж аймгийн таван зуу орчим хуурчдын бүртгэл, гурван зуу гаруй хуурын үлгэрийн бүртгэл гарган ажиглалт, тэмдэглэл хийн түүнийгээ системд оруулан эрдэм шинжилгээний гаргалгаа гаргаснаар жишээ татан хэлж болно.

Эрдэмтэн судлаач Б.Цогт 2001 онд хийсэн “Хуурын үлгэрийн судлал”-аа улам гүнзгийрүүлэн 2023 онд “Лувсан хуурчийн “Бодь мэргэн хаан”-ы судлал” хэмээх ганц сэдэвт бүтээл туурвижээ. Лувсан хуурч болон түүний хэлсэн “Бодь мэргэн хан” үлгэр хоёулаа өнөө цагийн монгол уран зохиолд чухал байр суурь эзэлдэг. 1885 онд Өвөр монголын Цахарын чуулганы Хуучид зүүн хошуунд төрөөд багаасаа Утай, Гүмбэн, Андуу, Лхас, Лавран, Манжуур, Буриад зэрэг газраар “тэнүүчлэн” юм үзэж нүд тайлсан, 1915 оны үеэр Монголд ирж тууль хайлж, хөгжим дуу тоглож явснаар барахгүй “Улсын гавьяат хөгжимчин шүлэг” цолыг хүртэл хүртэж явсан Лувсан хуурчийн намтрыг бас ч нэлээдгүй

судлан С.Ваанчиг, Т.Дашдорж, С.Цоодол, П.Хорлоо, С.Дэмбэрэл, Рэнцэндорж, Нарангэрэл, Д.Цэдэв нарын эрдэмтэд хэвлэн нийтэлсэн байдаг. Харин түүний хэлсэн “Бодь мэргэн хаан” үлгэрийг академич Б.Ренчин 1962 онд галигаар хэвлүүлснээс хойш нэг их судалгаа хийгдээгүй байснаас БНХАУ-ын Бээжингийн Их сургуулийн профессор Дулаан 2013 онд “Өлзийн Лувсан хуурчийн хэлсэн “Бодь мэргэн хаан” хэмээх үлгэрийн тухай судлал” хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн ба үүний дараа эрдэмтэн Цогтын “Бодь мэргэн хаан”-ы судлал” хэмээх ганц сэдэвт томоохон бүтээл гарсан юм.

Энэхүү “Лувсан хуурчийн “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн судлал” хэмээх судалгааны ганц сэдэвт бүтээл нь нэгд; өмнөх хуурын үлгэрийн судлалын ерөнхий онолын чиг баримжааг баримтлан нэг уран бүтээлчийн туурвилыг тодорхойлсон, хоёрт; Эсгий туургатны дунд тууль хайлах, үлгэр хэлэх туршлага, уран сайхны чадвараараа гайхагдсан Лувсан хуурчийн хэлсэн үлгэрийн хэлний, уран сайхны, шашны үзэл санааны туурвилыг дагнасан болон бусад үлгэр туультай харьцуулан шинжилснээрээ шинэ, утга соёлын судлалд ач холбогдолтой бүтээл болжээ гэж үнэлж байна. Юуны өмнө энэхүү ганц сэдэвт бүтээлд Лувсан хуурчийн хэлсэн “Бодь мэргэн хааны үлгэр”-ийн төрөл зүйлийг тууль эсвэл өгүүлэмжит үлгэр болох талаас өмнөх олон эрдэмтдийн саналыг харгалдуулан баримт жишээг нотолгоо болгон тууль бус үлгэр хэмээн батлан харуулсан байна.

“Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн судлалын эхний хэл соёлын шинжилгээний бүлэгт уламжлалт аман зохиолын дүрсэлгээ, хэл хэллэгийг тодруулахын зэрэгцээ хамгийн гол нь хятад хэл соёлын нөлөө туссан талаар тодорхой баримт сэлтийг оруулж өгсөн нь монгол-хятадын уран зохиолын харилцаа холбоо, харилцан нөлөөллийн асуудлыг судлах талаар онцгой анхаарч буй энэ үед их хэрэгтэй баримт болж өгсөн. Энэ талаар тодруулан хэлбэл хятад үг үсэг, хэллэгийг зээлдэн авч хэрэглэсэн нь нэлээд байна. Мөн хятадын эртний бичгийн зохиол романы мотивыг ашигласан байдал нь тухайн үед хэлэгдэж байсан хуурын үлгэрийн нийтлэг шинжийг хадгалахын зэрэгцээ хуурч Лувсан уламжлалт монгол үлгэр хайлах дэг ёсыг баримтлан цаг үе, нөхцөл байдал, “түүх”-ийн баримтуудыг хадгалан үлгэрээ зохиожээ гэж үзсэн нь судалгааны нэг томоохон дүгнэлт болжээ.

Профессор Цогт “Бодь мэргэн хаан”-ы үлгэрийн харьцуулсан судлал бүлэгтээ “Өлзийн Лувсан хуурчийн хэлсэн “Бодь мэргэн хаан”-ы үлгэр бол Мин улсын зохиолч Шюй жүн линий зохиосон шидэт роман “Сахиулсан өргөмжилсөн үлгэр”-ээс эхтэй гэж таамаглаж байна. Гэвч Лувсан хуурч тус үлгэрийг уул бэнсэн үлгэрийн хэвээр мөрдөн хэлсэн бус, харин үлгэр үйл явдлыг товчлох газар нь товчилж, өөрчлөх газар нь өөрчлөн, нэмэх газар нь нэмээд уул дүрийн хятад нэрийг бүгдийг монгол нэртэй үлгэр болгон зохион хэлсэн байна” гэсэн дүгнэлтийг хийсэн хятадын бичгийн уран зохиолын нөлөө монгол аман зохиолоор дамжин монголын уран зохиолд нөлөөлсөн томоохон баримт мөн юм. Энэ мэт бэнсний үлгэр, хуурын үлгэрийн харилцан нөлөөлөл нь

цаашид өөр бусад төрөл зүйлд халдан тархаж хятадаас ший янгуу, үргэлжилсэн зохиол ихэд дэлгэрэн хөгжих, монголд идээшин өөрчлөгдөх үйл явц маш идэвхтэй нөлөөлсөн гэж үзэж болно. Үүний тод жишээ бол Пүн Сүн Линий “Эрт эдүгээгийн гайхамшигт явдал” зохиолыг монголд идээшүүлэн баатрын нэр ба газар усны нэрийг монголчилсон Бодоогийн “Үзэмжит өгүүлэл” хэмээх томоохон хэмжээний зохиол мөн. Мөн Ц.Дамдинсүрэн алдарт “Тологдсон хүүхэн” туужаа бичсэн дурсамждаа (Эгшиг ба бусад 2016. 31) эртний энэтхэг, хятад төвөдийн зохиолуудыг их уншдаг байсан “Орогсдын ерөөл” зохиол нь энэхүү тууж бичихэд жишээ дуурайл болсон тухай өгүүлсэн байхад, М.Ядамсүрэнгийн “Турван хүүхэн” тууж, “Ухваргүй ярилцаан” (Дашдорж.1982) өгүүллэгүүд нь шууд хятадын бичгийн зохиолын нөлөөн доор бичигдсэн болохыг өнөө манай судлаачид нэгэнт тогтоогоод байна.

Дүгнэлт

Нэг. Монгол-хятадын уран зохиолын харилцаа холбооны судлалын асуудлын нэг гол судлагдахуун бол бэнсний үлгэр, хуурын үлгэр мөн бөгөөд энэ талаар анх удаа академич Б.Ренчин, Д.Цэрэнсодном нар Монгол улсад судлан тодорхой шинжлэх ухааны мэдээллүүдийг гаргасан ба харин үүнээс цааш БНХАУ-ын эрдэмтэд Дулаан, Цогт нар тодорхой төрөл зүйл, зохиол дээр нарийн задлан шинжилсэн бүтээл туурвиж энэ чиглэлд шинэ шинэ зам тавьж байна.

Хоёр. Энэ чиглэлд судалгааны “Хуурын үлгэрийн судлал”, “Лувсан хуурчийн “Бодь мэргэн хаан”-ы судлал” бүтээлээрээ дорвитой хувь нэмэр оруулсан эрдэмтэн бол БНХАУ-ын Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн профессор Б.Цогт мөн болно.

Abstract:

In this article, one of the main research topics in the study of Mongolian-Chinese literary communication is the folk tales and fiddle tales. For the first time, academicians B. Renchin and D. Tserensodnom studied them in Mongolia and published specific scientific information. Furthermore, Chinese scholars Dulaan and Tsogt have created detailed analytical works on specific genres and texts, paving the way for a new path in this direction. It is emphasized that the scholar who made a significant contribution to this direction with his works “Study of Fiddle Tales” and “Study of “Bodhi Khan the Wise” by the Luvsan Fiddler” is B. Tsogt, a professor at the Central University for Nationalities in Beijing, China.

Keywords: The tale of bens, the tale of the fiddler, Luvsan fiddler, Tsogt B.

Ном зүй

- Дулаан.** (2008). “Ц.Дамдинсүрэн хийгээд монгол хятад эртний уран зохиолын харьцаа холбооны судлал”. Академич Цэндийн Дамдинсүрэн дурсгалын түүвэр. Ред. Л.Хүрэлбаатар. Улаанбаатар. [Dulaan. *Ts.Damdinsüren khii-geed mongol khyatad ertnii uran zokhioliin khariltsaa kholboonii sudlal*. [A Study on the relationship between Ancient Mongolian and Chinese Literature then Ts. Damdinsuren’s] Memorial Collection of Academician Tsendin Damdinsuren. Ed. L. Khurelbaatar. Ulaanbaatar. 2008.]
- Цэрэнсодном, Д.** (2017). *Бичгийн хүмүүний бийрийн увдис*. ред. С.Байгалсайхан. Улаанбаатар. [Tserensodnom, D. *Bichgiin khümüünii biiriin uvdis* [The Charm of The Intellectual]. Ed. S.Baigalsaikhan. Ulaanbaatar. 2017.]
- Хөвсгөл, С.** (2010). *Дорно дахины уран зохиол*. Улаанбаатар. [Khuvsgul, S. *Dorno dahinii uran zohiol* [Oriental Literature]. Ulaanbaatar. 2010]
- Байгалсайхан, С.** (2023). Өмнөх үг. *Лувсан хуурчийн бодь мэргэн хаан*”-ы судлал. Улаанбаатар. [Baigalsaikhan, S. *Luvсан khuurchiin bodi mergen khaanii sudlal*. [Foreword. A Study of “Bodi Mergen Khan by the fiddler Luvsan”]. Ulaanbaatar. 2023]
- Мандах.** (2023). *Оршил. Лувсан хуурчийн бодь мэргэн хаан*”-ы судлал. Улаанбаатар. [Mandah. Orshil. *Luvсан khuurchiin bodi mergen khaanii sudlal*. [Introduction. A Study of “Bodi Mergen Khan by the fiddler Luvsan”. Ulaanbaatar. 2023]
- Эгшиг. Ш, Гэрэлтөв. Д, Сүхбаатар. О, Бадрал. Ё,** (2016). *Цайны зам*. Улаанбаатар. [Egshig. Sh, Gereltev. D, Sukhbaatar. Oh, Badral. Yo, *Tsainii zam* [Tea Road. Ulaanbaatar. 2016.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.